

ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТЫГ АВЧ ҮЗЭХ НЬ

Ч.Отгонсүрэн

Хуульч, судлаач Чимэдийн Отгонсүрэн

Товч агуулга. Авлигын гэмт хэрэг нь улс орны хөгжилд саад тотгор болж, эдийн засаг, нийгмийн байдлыг доройтуулж, иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог тул эрүүгийн эрх зүйн тусгай ангийн тогтолцооны нэг бүрэлдэхүүн болдог.

Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенцоор тодорхойлсон авлигын гэмт хэрэгт үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг хамаарах бөгөөд манай улсын Үндсэн хууль, эрх зүйн тогтолцооны үндсэн зарчимд харшлаагүй тул дээрх конвенцод нэгдсэн орсон билээ.

Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу эрүүгийн хууль тогтоомждоо үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг хуульчилсан. Энэ гэмт хэрэг шинэ ойлголт биш боловч гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримт цуглуулах, хариуцлага хүлээлгэх механизм нь ихээхэн төвөгтэй байдаг нь гэмт хэргийн судалгаанаас харагдана.

Хураангуй: Энэхүү өгүүллээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн үүсэл хөгжил, ойлголтын талаар авч үзэж, эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, түүний практик хэрэглээний талаар судлахыг зорилоо.

Түлхүүр үг: Эрүүгийн эрх зүй, гэмт хэрэг, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, авлига, конвенц, албан тушаалтан, хөрөнгө

А. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн үүсэл хөгжил

Авлигын гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтныг илрүүлэх, яллах явцад томоохон хэмжээний асуудалтай тулгарах⁹⁸ ба гэмт хэргийг илрүүлэхэд уламжлалт мөрдөн байцаалтын арга, техникийг ашиглахад олон жил шаардагддаг.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд багагүй цаг хугацааг зарцуулдаг ч нотлох баримтын хүрэлцээгүй шалтгаанаар хэргийг хэрэгсэхгүй болгох нь ердийн үзэгдэл болсон байна. Авлигын гэмт хэрэг нь нэг талаас авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг буруутгах, улмаар яллах нөхцөл

⁹⁸ Boles, J. (2014) "Criminalizing the Problem of Unexplained Wealth: Illicit Enrichment Offenses and Human Rights Violations",

Journal of legislation and public policy Vol. 17, pp. 836

байдал нь хүнд байдаг⁹⁹ бол нөгөө талаас албан тушаалтны хууль ёсны орлогоос давсан өндөр дүнтэй гэмт хэргийн шинжтэй үйлдэл байдаг.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь 5 үндсэн элементээс бүрдэх ба 1) төрийн албан хаагч байх, 2) төрийн албанд ажиллах хугацаанд байх, 3) хууль ёсны орлогоос мэдэгдэхүйц өссөн байх, 4) санаатай үйлдэл байх, 5) хууль зүйн үндэслэлгүй нэмэгдсэн байдаг¹⁰⁰. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь баялгийг хянах Засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлэх, төрийн салбарын ил тод байдлыг сайжруулах¹⁰¹ гэх мэт давуу талууд бий болж байна.

Хууль ёсны орлогоос давсан өндөр орлогыг хураан авах саналыг 1930-аад оны Аргентины конгрессын гишүүн Родольфо Короминас Сегура хууль ёсны болон хөрөнгө орлогын мэдүүлгээр мэдүүлсэн орлого нь асар зөрүүтэй байгааг тооцоолж¹⁰², их хэмжээний хөрөнгөтэй төрийн албан хаагчтэй уулзсаны дараа “хууль бусаар

хөрөнгөжих” тухай хуулийн төслийг танилцуулсан боловч улс төрийн хүчин зүйлсээс болж, батлагдаагүй байна. Гэхдээ хууль бусаар хөрөнгөжих олон улсын баримт бичиг, үндэсний хууль тогтоомжид тусах үзэл баримтлалд нөлөөлж, урьдач нөхцөл болсон. 1950-иад оны эхээр БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконгод төрийн албан тушаалтнууд албан ёсны цалин хөлстэй нь үл нийцэх амьжиргааны төвшинг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадаагүй төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах журам гаргажээ¹⁰³. Энэ нь Хонгконгод 1971 оны үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуулийн суурь нөхцөл болсон гэж үздэг. Үүний дараагаар Египет, Сенегал, Энэтхэг, Куба, Турк, Нигер гэх мэт бусад улсууд үндэслэлгүй хөрөнгө эзэмшихээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг нэвтрүүлсэн¹⁰⁴ байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих ойлголттой холбоотой олон улсын түвшинд ахиц гарсан үйл явдал нь 1996 оны Авлигын эсрэг Америк тивийн улс хоорондын конвенцын 9

⁹⁹ Stojanović, Z. (2019) “Illicit enrichment of public officials as a criminal offence?” in: *Studia Iuridica Montenegrina*, No. 1, pp. 115

¹⁰⁰ Muzila, L., Morales, M., Mathias, M., Berger, T. (2012) *On the Take: Criminalizing Illicit Enrichment to Fight Corruption*. Washington: The World Bank (analyzing the five principal elements common to most illicit enrichment statutes).

¹⁰¹ Joanna E. MacMillan, *Reformasi and Public Corruption: Why Indonesia's AntiCorruption Agency Strategy Must be Reformed to*

Effectively Combat Public Corruption, 25 EMORY INT'L L. REV. 587, 627 (2011).

¹⁰² Muzila, L., Morales, M., Mathias, M., Berger, T. (2012) *On the Take: Criminalizing Illicit Enrichment to Fight Corruption*. Washington: The World Bank. 2017, p.7

¹⁰³ Dornbierer, A. (2021) *Illicit Enrichment: A Guide to Laws Targeting Unexplained Wealth*. Basel: Basel Institute on Governance. p.22

¹⁰⁴ Aleksandar Stevanović, Laura Maria Stănilă “Illicit enrichment as a criminal offense: possibility of implementation in the national criminal legislations”.,2021, p.207

дүгээр зүйлд “төрийн албан хаагч албан тушаал хаших явцад түүний хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн хууль ёсны орлогын хүрээнд үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байх...”¹⁰⁵ гэж тодорхойлсон явдал юм. Энэ конвенцоос долоон жилийн дараа 2003 онд Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Африкийн холбооны конвенцын 1 дүгээр зүйлд “.... төрийн албан хаагч эсхүл аливаа хувь хүний хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийн орлогын хүрээнд үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байх”¹⁰⁶ гэж тодорхойлсон нь үндэслэлгүй хөрөнгөжих тухай ойлголтыг авч үзсэн олон талт гэрээ болсон юм.

Үүний дараагаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 20 дугаар зүйлээр хууль бусаар баяжих ойлголтыг тодорхойлсон нь олон улсад хүлээн зөвшөөрөх бүх нийтийн ойлголттой болсон. Үндсэн хууль, эрх зүйн тогтолцооны үндсэн зарчимд харшлаагүй тохиолдолд улс орон өөрийн эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ ойлголт Хойд Америк болон Баруун Европын зарим орнуудыг эс тооцвол дэлхийн ихэнх улс оронд хууль бусаар баяжих заалтууд бий¹⁰⁷.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих нь зөвхөн эрүүгийн эрх зүйд хамааралтай ойлголт биш бөгөөд гэрээний харилцаанд аль нэг тал нь хууль зүйн үндэслэлгүйгээр гэрээний үнийг өсгөж байгаа байдлыг зохицуулах зорилгоор иргэний эрх зүйд ч хөгжүүлсэн байна. Үндэслэлгүй хөрөнгө гэж тодорхойлж болох энэ ойлголт нь гэмт хэргийн улмаас алдагдсан эд хөрөнгийг олж авах, эрүүгийн эрх зүйн үндсэн чиг үүрэг болох урьдчилан сэргийлэх үүргийг биелүүлж гэмт этгээдийг шийтгэх зорилгыг агуулдаг.

В. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт

2002 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орж¹⁰⁸, албан тушаалын гэмт хэрэгт хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг хамааруулсан юм. Учир нь нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олох нь хууль бус ба нийтийн албан тушаалд томилогдсон этгээд бусдад нөлөө үзүүлэх, эрх мэдлээ хэтрүүлэх, гэмт хэрэг үйлдэж болзошгүй явдлыг таслан зогсоох явдал юм. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хууль бусаар

¹⁰⁵ Inter-American Convention Against Corruption, Article 9.

¹⁰⁶ African Union Convention on Preventing and Combating Corruption, Article 1

¹⁰⁷ Muzila, L., Morales, M., Mathias, M., Berger, T. (2012) On the Take: Criminalizing Illicit

Enrichment to Fight Corruption. Washington: The World Bank. p.9

¹⁰⁸ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл /2012.01.19/

хөрөнгөжих гэмт хэргийг үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг болгон өөрчилж, үндсэн шинжийг нь нийтийн албан тушаалтан өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэж тодорхойлсон юм. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан этгээд яллах дүгнэлтэд дурдагдсан эд хөрөнгө, орлогыг хууль ёсоор олсон гэдгийг тайлбарлах үүргийг хүлээлгэсэн агуулгатай болсон.

Харин 2022 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн үндсэн шинжийг нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон гэж өөрчлөлт оруулсан юм. Энэ нь олон улсын гэрээ, конвенц¹⁰⁹ болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан¹¹⁰ нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн язгуур зарчмыг хууль хэрэгжүүлэгч албан тушаалтан чанд сахин мөрдөж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд элдэв болзол, нөхцөлгүйгээр эдлүүлэх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж

болзошгүй хүн өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, хэргийн бодит байдлыг нотлох, гэмт хэрэгт холбогдолтой болохыг нотлоход чиглэгдсэн аливаа баримтыг хууль хэрэгжүүлэгчийг очтол хадгалах, эсхүл түүнд хүлээлгэж өгөх үүрэг хүлээдэггүйтэй холбоотой.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн хүндрүүлэх шинж нь улс төрд нөлөө бүхий этгээд байх ба хууль тогтоогчийн зүгээс "улс төрд нөлөө бүхий этгээд" гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно¹¹¹ гэдэг аутентик байдлаар тайлбарласан.

Мөн энэ гэмт хэргийн үндсэн шинж хангагдахын тулд *нэгдүгээрт*, нийтийн албан тушаалтан байх, *хоёрдугаарт*, хохирлын хэмжээ их

¹⁰⁹ Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 3-ын (g)-д "Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй".

¹¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14-т "өөрийн ... эсрэг мэдүүлэг өгөхгүй байх"; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар

зүйлийн 4-д "Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно".

¹¹¹ Эрүүгийн хууль /2015/-ийн шинэчилсэн найруулгын 21.6 дугаар зүйлийн тайлбар хэсгээс үзнэ үү

буюу зуун сая төгрөг, түүнээс дээш хэмжээтэй байх, *гуравдугаарт*, хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон байх, *дөрөвдүгээрт*, хөрөнгө орлого нь албан тушаал эрхэлж байсан үед нь бий болсон байх шаардлага тавигдах юм. Эдгээр үндсэн шинж хангагдахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн шинж үгүйсгэгдэнэ.

2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэгт "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгохоор заасан байхад хууль тогтоогчид 2022 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр¹¹² авлигын гэмт хэрэгт буюу "хахууль авах", "үндэслэлгүйгээр хөрөнгөжих" гэмт хэрэгт нэмэлт тайлбар гаргаж "их хэмжээ" гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно гэж заасан нь Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж, ялгаатай байдал нь Үндсэн хуулийн зөрчил үүсгэж болзошгүй юм.

Өөрөөр хэлбэл, энгийн иргэд тавин сая төгрөгийн хохирол, учруулбал эрүүгийн хариуцлага

хүлээдэг, харин албан тушаалтан нэг зуун сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнгээр хууль бусаар хөрөнгөжвөл эрүүгийн хариуцлага хүлээдэг байхаар харьцангуй зохицуулжээ.

В. Шүүхийн практик

Улсын хэмжээнд 2017-2023 оны хооронд үндэслэлгүйгээр хөрөнгөжих нийт 8 гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс гурван шатны шүүхээр хянан хэлэлцэгдэж, цагаатгасан нэг хэргийг онцлон дурдвас,

Улс төрд нөлөө бүхий этгээд Э нь 3 жил гаруйн хугацаанд яамны төрийн нарийн бичгийн дарга буюу нийтийн албан тушаалтнаар ажиллахдаа 1,141,800,000 төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө (орон сууц, автомашины зогсоол) -ийг худалдан авч, хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэн боловч уг хөрөнгийг хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэмт хэрэгт, мөн түүний багын найз Г нь Э-ийн эзэмшлийн дээрх үл хөдлөх хөрөнгийг өөрийн нэр дээр бүртгүүлж, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг үйлдэхэд нь учрах саадыг арилган дэмжлэг үзүүлж хамтран оролцсон гэмт хэрэгт тус тус холбогджээ.

¹¹² Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /2022.12.16/

Анхан шатны шүүх шүүгдэгч нарын үйлдлийг Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр цагаатгасан байна. Учир нь Монгол Улсын Их хурлаас 2015 оны 8 дугаар сарын 07-ны өдөр Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг баталж, энэ хуулиар хувь хүн, хуулийн этгээд бусдын нэр дээр бүртгүүлсэн, нуун дарагдуулсан өөрийн өмчлөлийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй адилтгах бусад хөрөнгө, олсон орлого, үзүүлсэн үйлчилгээгээ ил тод болгон үнэн зөв, шударгаар санхүү, татварын болон нийгмийн даатгалын тайланд тусгаж, шинээр тайлагнасан, гаалийн байгууллагад нөхөн мэдүүлсэн, улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн байх ба эдгээр үйл ажиллагаа нь хувь хүн, хуулийн этгээдийн зүгээс сайн дурын үндсэн дээр хийгдсэн тохиолдолд тэдгээрийг хуульд заасан хариуцлага болон албан татвараас нэг удаа чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан юм.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсан хэрэгт холбогдсон шүүгдэгч нар Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу өөрийн нэр дээрх хөрөнгийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн тул эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзсан

байна. Мөн уг хуульд хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хувь хүн, хуулийн этгээдэд ийнхүү чөлөөлөгдөхөөр заасан үндэслэлээр дахин эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглохоор заажээ.

Давж заалдах шатны шүүх 2 асуудалд дүгнэлт хийсэн ба нэгдүгээрт, шүүгдэгч Э-г нийтийн албан тушаалд ажиллах хугацаандаа орон сууц, автомашины зогсоолуудыг худалдан авснаа хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй гэж үзэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр хэргийг зүйлчилж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан хууль буцаан хэрэглэх зарчмыг зөрчсөн байна. Хоёрдугаарт, шүүгдэгч Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу өөрийн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн үйлчлэлд хамруулсан үл хөдлөх эд хөрөнгүүдийн эх сурвалжийг тогтоох зорилгоор шүүгдэгчид эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэмт хэрэгт яллагдагчаар татсан зөрчил тогтоогдсон тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Улсын дээд шүүх үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эд хөрөнгө нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эзэмшил, ашиглалд бус өмчлөлд байсан нь тогтоогдсон бөгөөд өмчлөгч нь нийтийн албан тушаалтан байх хуулийн шаардлага нь уг гэмт хэргийн субъектийг тодорхойлохоос гадна зөвхөн түүний үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн зарчмын агуулгад нийцнэ. Иймд Г нь нийтийн албан тушаалтан биш буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъект биш тул хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүгдэгч Э нь шүүхэд найзаасаа мөнгө зээлж, зээлийн баталгаа болгож, захиалгын гэрээ хийсэн, гэр бүлийн бизнес болох үнэт эдлэлийн худалдааны орлого, орон сууцыг худалдан борлуулсан орлого, бусдаас авах авлага, хувь хүнээс авсан зээл, авлага зэрэг орлогынхоо үнийн дүнг тодорхойлж, энэхүү мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгүүдийг худалдан авсан” гэж тайлбарласныг прокурорын зүгээс нотлох баримтаар няцаан үгүйсгэж, эргэлзээтэй гэж үзэж буйгаа нотолж чадаагүй, яллах дүгнэлт ямар нэг үндэслэл бүхий үйл баримт, нөхцөл байдалд тулгуурлаагүй байх тул Э-гийн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр цагаатгаж шийдвэрлэсэн хоёр шатны шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Эндээс дүгнэж үзвэл нэгдүгээрт, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримтаар тогтооход хүндрэлтэй байх ба гэмт хэрэгт холбогдсон нийтийн албан тушаалтан гэмт хэргээ нийтийн албан тушаалтан биш этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой байна. Учир нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъект нь заавал нийтийн албан тушаалтан байх явдал юм. Хоёрдугаарт, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай нэг удаагийн үйлчлэлтэй хуулинд авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хамрагдах боломжтой байдлаар нээлттэй хуульчилсан нь албан тушаалтууд хууль бусаар олж авсан хөрөнгө, орлогоо ил болгож, бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэнээр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өршөөх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзах, гэмт хэрэгтэнд ял завших боломжийг олгосон зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Дүгнэлт

Эх сурвалж тодорхойгүй хөрөнгөөр баяжиж буй төрийн албан хаагчдын үйлдлийг таслан зогсоох, хөрөнгө, орлого нь үндэслэлгүй нэмэгдсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох, тухайн хөрөнгийг хураах санаачилга анх гарч эхэлснээс хойш ихэнх улс орон энэ үйлдлийг Эрүүгийн хуульдаа нутагшуулах хандлага дэлгэрч, өнөөг хүрчээ.

Манай улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нэгдсэнээр олон улсын гэрээгээр бусад улс орны өмнө үүрэг хүлээсэн юм. Энэ үүрэг нь конвенцод тусгагдсан гэмт хэргийг өөрийн орны хууль тогтоомждоо нийцүүлэх байдлаар илэрсэн нь харагдаж байна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн үндсэн шинжид “их хэмжээ”-г тодорхойлж өгсөн нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцтэй нийцэж байгаа ч нөгөө талаас албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна нэг зуун сая төгрөг хүртэлх үнийн дүнгээр хөрөнгө, орлогоо нэмэгдүүлсэн ч эрүүгийн хуулийн хариуцлага хүлээхгүй юм.

Авлигын гэмт хэрэг нь улс орны нийгмийн тогтвортой байдал, ардчиллын тогтолцоо, үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулдаг тул энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариуцлага хүлээлгэх нь зүйтэй.

Мөн авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн үйлчлэлд хамруулж байгаа нь хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, хараат бусаар ажиллах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, шалган шийдвэрлэх зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

Ном зүй

Эрх зүйн эх сурвалж

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц /2003/
2. Эрүүгийн хууль /2015/
3. Авлигын эсрэг хууль /2006/
4. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль /2015/

Монгол эх сурвалж

1. Эндрью Дорнбьерер “Үндэслэлгүй хөрөнгөжилт: тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага”, 2021
2. Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шүүмж, шүүхийн практик., гарын авлага. УБ., 2022

Гадаад эх сурвалж

1. Aleksandar Stevanović, Laura Maria Stănilă “Illicit enrichment as a criminal offense: possibility of implementation in the national criminal legislations”, 2021
2. Boles, J. (2014) “Criminalizing the Problem of Unexplained Wealth: Illicit Enrichment Offenses and Human Rights Violations”, Journal of legislation and public policy Vol. 17

3. Dornbierer, A. (2021) *Illicit Enrichment: A Guide to Laws Targeting Unexplained Wealth*. Basel: Basel Institute on Governance
4. Muzila, L., Morales, M., Mathias, M., Berger, T. (2012) *On the Take: Criminalizing Illicit Enrichment to Fight Corruption*. Washington: The World Bank.
5. Stojanović, Z. (2019) "Illicit enrichment of public officials as a criminal offence?" in: *Studia Iuridica Montenegrina*, No. 1